



**УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ**



**УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙГ 2023-2024 ОНД  
ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**УЛААНБААТАР ХОТ  
2023 он**

---

## АГУУЛГА

НЭГ.	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	5
ХОЁР.	МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ.....	6
ГУРАВ.	АЛСЫН ХАРАА .....	14
ДӨРӨВ.	ЭРХЭМ ЗОРИЛГО .....	14
ТАВ.	ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ .....	15
ЗУРГАА.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО .....	23
ДОЛОО.	МУЗЕЙН ТАНИЛЦУУЛГА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	24
НАЙМ.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ СУУРЬ ТҮВШИН, ЗОРИЛТОТ ТҮВШИН.....	26

---

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. <i>Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулиуд</i> .....	6
Хүснэгт 2. <i>Улаанбаатар хотын музейн чиг үүрэг, үйл ажиллагааны ангиллаар</i> .....	7
Хүснэгт 3. <i>Холбогдогч талуудын оролцоо</i> .....	12
Хүснэгт 4. <i>Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааны төлөвлөлтийг гурван чиг үүрэгт хуваан ангилж үзэхэд</i> .....	13
Хүснэгт 5. <i>2022 оны Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл</i> .....	17-18
Хүснэгт 6. <i>Улаанбаатар хотын музейн бүтэц, орон тоо</i> .....	18
Хүснэгт 7. <i>Свог шинжилгээ</i> .....	22
Хүснэгт 8. <i>Улаанбаатар хотын музейн стратегийн зорилго</i> .....	23
Хүснэгт 9. <i>Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин</i> .....	27

---

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаанд холбогдогч талууд.....	11
Зураг 2. Улаанбаатар хотын музейн 2021, 2022 оны төлөвлөгөөний биелэлт (хувиар).....	16
Зураг 3. Холбогдогч талуудын оролцоо .....	12
Зураг 4. Албан хаагчдын төрийн албанд ажилласан жил, (хувиар).....	19
Зураг 5. Албан хаагчдын боловсролын түвшин (хувиар).....	20

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийг 2020 онд шинэчлэн баталсан. Уг хуульд зааснаар Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна. Нийслэлийн хувьд дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна. Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Төрийн албаны тухай хууль (2017 оны шинэчилсэн найруулга)-ийн 53 дугаар зүйлийн 53.1-д зааснаар “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж тусгасан.

Дэлхий нийтийг хамарсан даяаршлын үйл явцын эрчимтэй нөлөө, үндэстэн дамнасан соёл хоорондын харилцааны идэвхитэй хөгжил, дэлхий дахины болон улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд явагдаж буй түргэн хурдацтай өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлс соёлын салбарыг хөгжлийн шинэ шатанд гаргах шаардлагыг тодорхойлж байна. Иймд Улаанбаатар музейн хувьд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн байгууллагыг хөгжлийн шинэ шатанд хүргэхэд одоогийн нөхцөл байдлыг бодитой судлан шинжилж, хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн залгамж чанарыг хадгалан, үйл ажиллагаагаа орчин үеийн дэвшилтэт технологид тулгуурлан улам эрчимжүүлэх, байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дунд хугацааны стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч Улаанбаатар хотын музейн 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулсан.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь төрийн байгууллагын хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээтэй холбоотой байдаг. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд тусгаснаар “чиг үүрэг” гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл юм.

Улаанбаатар хотын музейн 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд мандатын буюу чиг үүргийн шинжилгээг хийхдээ Соёлын салбарт шууд хамаарах 6 хууль, төрийн алба төсөв санхүү зэрэгт хамаарах 8 буюу нийт 14 хуулиар олгосон чиг үүргийг хамруулан авч үзэн, дараах чиг үүргийн хүрээнд мандатын шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг тодорхойлох
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилал
3. Салбар хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зэрэг ажлууд орсон.

Алхам 1. Чиг үүргийг тодорхойлж ангилах  
Мандатын шинжилгээний үр дүнд Нийслэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгагдсан музейд хамааралтай

- Соёлын бодлогыг хэрэгжүүлэх 1 үндсэн чиг үүрэг, 2 дэд чиг үүрэг,
- Улаанбаатар хотын соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх хүрээнд дүрмээр хүлээсэн 1 үндсэн чиг үүрэг, 9 дэд чиг үүрэг,
- Музейн захиргаа, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хуулиар олгосон 2 үндсэн чиг үүрэг, 7 дэд чиг үүрэг нийт 4 үндсэн чиг үүрэг, 18 дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, доорх хүснэгтээр дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Хүснэгт 1. Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулиуд

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		14
Тухайн салбарын хуулиуд Тоо: 6		<ol style="list-style-type: none"> <li>1. Соёлын тухай; (2021)</li> <li>2. Музейн тухай; (2021)</li> <li>3. Соёлын өвийг хамгаалах тухай; (2014)</li> <li>4. Боловсролын тухай; (2002)</li> <li>5. Оюуны өмчийн тухай; (2020)</li> <li>6. Улаанбаатар хотын музейн дүрэм; (2016)</li> </ol>
Үүнээс:	Нийтлэг мөрддөг хуулиуд Тоо: 8	<ol style="list-style-type: none"> <li>1. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай; (2020)</li> <li>2. Хөдөлмөрийн тухай хууль; (2021)</li> <li>3. Төрийн албаны тухай; (2017)</li> <li>4. Төсвийн тухай; (2011)</li> <li>5. Нягтлан бодох бүртгэлийн тухай; (2015)</li> <li>6. Шилэн дансны тухай; (2014)</li> <li>7. Архив албан бичиг хөтлөлтийн тухай; (2020)</li> <li>8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай; (2021)</li> </ol>

Хүснэгт 2. Улаанбаатар хотын музейн чиг үүрэг, үйл ажиллагааны ангиллаар

№	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хуулийн нэр, заалт, бодлогын баримт бичгийн батлагдсан дугаар, дүрэм журмын дугаар	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Нийслэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгагдсан музейд хамааралтай соёлын бодлогыг хэрэгжүүлэх				
1.1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Үндэсний агуулга	1.1.1.Улаанбаатар хотын музейн барилгыг засварлаж үйл ажиллагааг боловсрол, түүх соёлын чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлнэ.	НЗДҮАХ 2.6 НЗДҮАХ-2.6.2.3	Соёлын Яам НЗДТГ НСУГ Улаанбаатар хотын музей
1.2	бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.	1.1.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг оюуны өмч зохиогчийн эрх, инновацид тулгуурлан хөгжүүлнэ	НЗДҮАХ-2.6.5	Оюуны өмчийн газар НСУГ Улаанбаатар хотын музей
2.Улаанбаатар хотын соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх				
2.1	Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх	2.1.1.Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгааг хийж, сан хөмрөгийг баяжуулна.	УБХМД-4.2.1	УБХМ НӨХГ Бусад байгууллага Хувь хүн
		2.1.2.Музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын	УБХМД-4.2.2	УБХМ СӨҮТ

		баталгаат орчин бүрдүүлж, үзмэрийг арчлан тордон, сэргээн засварлана.		
		2.1.3. Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ.	УБХМД-4.2.3	УБХМ СӨҮТ
		2.1.4. Музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзүүлэгийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгоно.	УБХМД-4.2.4	НСУГ УБХМ
		2.1.5. Музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулна.	УБХМД-4.2.5	УБХМ Судалгааны байгууллагууд
		2.1.6. Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна.	УБХМД-4.2.6	УБХМ НБГ
		2.1.7. Музейн цуглуулгын каталог, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном, хэвлэл бэлтгэн нийтэлнэ.	УБХМД-4.2.7	УБХМ ААНБ Хувь судлаачид
		2.1.8. Соёлын биет өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн	УБХМД-4.2.8	СӨҮТ НСУГ



		санг бүрдүүлж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд холбогдох мэдээллийг дамжуулна.		УБХМ
		2.1.9. Музей нь өөрийн цахим хуудастай байна. Цахим хуудсанд музейн эрхэм зорилго, байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, музейгээс зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэнгийн мэдээ мэдээлэл, санхүүжилт, төлбөр хураамж, санал, хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан эргэх холбоог хангаж ажиллана.	УБХМД-4.2.9	УБХМ
3.Музейн захиргаа, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				
3.1	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх	Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулж, санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлэх, НББ хууль, дүрэм журмыг стандартын дагуу хэрэгжүүлэх	Төсвийн тухай хууль НББТХ Шилэн дансны тухай хууль	УБХМ НДГ МТА НЗДТГ
		Архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын ажлын зохион байгуулалтыг хууль тогтоомж, стандарт, журам зааврын дагуу хөтлөн явуулах, шийдвэрлэх	ААХХТХ	НАГ
		Музейн ажилтнуудын ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг тооцох,	Байгууллагын хөдөлмөрийн	УБХМ НЗДТГ НСУГ

		хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэн гаргаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох байгуулагад хугацаанд нь хүргүүлэх	дотоод журам	
		Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам	УБХМ
4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ил тод шилэн байх				
4.1	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх	Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулан хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх		УБХМ
		Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах	ШДТХ	УБХМ
		Төсвийн гүйцэтгэлийн биелэлт санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, үйл ажиллагааг байгууллагын цахим хуудсанд ил тод байрлуулан иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх	НББТХ ШДТХ	УБХМ

## Алхам 2. Холбогдогч талуудыг тодорхойлох

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Улаанбаатар хотын музейгээс бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэн тодорхойлов. Улаанбаатар хотын музей нь доорх хэлбэрээр үйл ажиллагаагаа зохион байгуулдаг байна. Үүнд:

1. Дээшээ чиглэлд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг тооцох, мэдээллээр хангах, ажлынхаа үр дүнг тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, захиргаа аж ахуй, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг авах,
2. Хэвтээ чиглэлд нийслэлийн харьяа байгууллага, чиг үүрэг ижил төстэй соёлын байгууллагууд, ТББ, ААН байгууллага, иргэдийг бодлогын удирдамжаар хамтран ажиллах, мэдээллээр хангах, санал хүсэлтийг хүлээн авах, эргэх холбоогоор хангах, үйлчилгээ үзүүлэх, хөтөлбөр төслийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх, үр дүнг тооцох,
3. Доошоо буюу дотогшоо чиглэлд байгууллагыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, стратегийн төлөвлөлт хийх, төсөл хөтөлбөр зохиох, архив бичиг хэргийг хөтлөх, мэргэжилтэн хоорондын ажил үүргийг уялдуулан зохицуулах, хяналт тавих, үр дүнг тооцох.

Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах зурагт харуулав.

Зураг 1. Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаанд холбогдогч талууд



Дээрх холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах, хяналт тавих гэсэн байдлаар тодорхойлон ангилж Улаанбаатар хотын музей нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдгээр холбогдогч талуудтай өөрт хамаарах эрх хэмжээний хүрээнд тодорхой үүрэг оролцоотойгоор хамтран ажиллах болно. Хамтран ажиллах хамаарлыг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо*

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Хяналт тавих
Соёлын Яам	√	√	√	√	√	√
НЗДТГ	√	√	√	√	√	√
Соёлын Өвийн Үндэсний төв	√	√	√	√		√
НСУГ	√	√	√	√	√	√
Нийслэлийн харьяа нутгийн захиргааны байгууллагууд	√		√	√		
Олон улсын байгууллагууд	√		√	√		
Хэвлэл мэдээллийн байгууллагууд	√		√	√		
Бусад музей	√	√	√	√		
Боловсролын байгууллагууд	√		√	√		
ААН, ТББ	√	√	√	√		
Иргэд	√	√	√	√		

Алхам 3. Чиг үүргийн хэрэгжилт, хяналт шинжилгээ үнэлгээ

Хүснэгт 4. Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааны төлөвлөлтийг гурван чиг үүрэгт хуваан ангилж үзэхэд:

Чиг үүрэг	2021		2022	
	Арга хэмжээ тоо	Хэрэгжилт хувиар	Арга хэмжээ тоо	Хэрэгжилт хувиар
Нийслэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгагдсан музейд хамааралтай соёлын бодлогыг хэрэгжүүлэх	1	2,9	2	3,9
Улаанбаатар хотын соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	22	64,7	32	62,7
Музейн захиргаа, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	11	32,4	17	33,4
Нийт төлөвлөгөөнд тусгагдсан	34	100	51	100
Нэмэлт ажлууд	23	-	32	-
Нийт	57	-	83	-

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн НЗДҮАХ 2.6 НЗДҮАХ-2.6.2.3 “Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгааг хийж, сан хөмрөгийг баяжуулна” заалтын дагуу 2021, 2022 оны төлөвлөгөөндөө “Музейн барилгыг түүхэн байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөлийн шинэ барилга барих санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.” хэмээн оруулж Улаанбаатар хотын музейн барилгыг түүхэн дурсгалт байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, шинэ өргөтгөлийн барилга барих, музейг дэглэх, тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийг боловсруулж саналаа НЗДТГ, НСУГ-г хүргүүлсэн хэдий ч Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2021-2025 оны үндсэн чиглэлд шинэ өргөтгөлийн барилга барих санал тусгагдаагүй ба ирэх 5 жилд музейн шинэ барилга баригдах эсэх асуудал тодорхойгүй хэвээр байна. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619 дугаар захирамжаар музейн өргөтгөлийн шинэ барилгын зураг төсөл боловсруулах хөрөнгийг шийдвэрлэснээр тендерт Тито архитектс ХХК шалгарч, зураг төслийг боловсруулан хийж дуусгасан. Музейн захиргаанаас 2021-2025 оны

---

үндсэн чиглэлд шинэ өргөтгөлийн барилга барих саналаа явуулсан хэдий ч ирэх 5 жилд музейн шинэ барилга баригдах эсэх асуудал тодорхойгүй хэвээр байна.

#### Хяналт, шинжилгээ үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох хууль журмын дагуу хийж гүйцэтгэсэн. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг үнэлэхэд 4 зорилтын хүрээнд нийт 34 арга хэмжээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр дундаж нь **98,47** хувийн гүйцэтгэлтэй, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг үнэлэхэд 5 зорилтын хүрээнд нийт 51 арга хэмжээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр дундаж нь **98,3** хувийн тус тус гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

Нийслэлийн засаг даргын А/1504 дүгээр захирамжийн дагуу төсөвт байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгөх ажлын хэсэгт батлагдсан удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу шалгуулж “ХАНГАЛТТАЙ” үнэлгээ авсан.

#### ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Алсын хараа нь байгууллагын ирээдүйн төлөвийг илэрхийлж, хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон байдаг. Энэ нь хэтийн төлөв болон өнөөгийн бодит байдлын аль алиныг нь агуулсан байх бөгөөд хэтийн төлөвийг хийсвэрээр бус, харин ирээдүйд юунд хүрэхийг томъёолсон хэлбэрээр тодорхойлогддог.

Байгууллагын үйл ажиллагаа нь бүхэлдээ алсын хараандаа чиглэх бөгөөд алсын хараа нь ажилтан бүрийг амжилт, үр дүнд уриалан өдөөж байдаг. Алсын хараа нь ажилтнуудыг амжилт дэвшилд хөтлөх уриа дуудлага юм.



**АЛСЫН ХАРАА:**  
**УЛААНБААТАР ХОТЫН ТҮҮХИЙН БАЯЛАГ**  
**УЛАМЖЛАЛ, ҮНЭТ ЗҮЙЛСЭЭР БАХАРХАХ ҮЗЭЛ САНААГ**  
**ТӨЛӨВШҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ ДЭЛХИЙ ДАХИНД**  
**ДЭЛГЭРҮҮЛЭХЭД ТҮҮЧЭЭЛЭГЧ БАЙГУУЛЛАГА БОЛНО.**

#### УРИА:

**БИД БҮГД ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭГЧ БАЙЯ.**

#### ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Өнөөгийн нийгэм даяарчлалд музейн үйл ажиллагааг нийцүүлж, музейн менежмент, маркетинг, хүний нөөцийн удирдлагыг оновчтой хөгжүүлэх замаар олон нийтэд нээлттэй, байнгын тасралтгүй үйл ажиллагаатай, иргэдэд үзүүлэх үйлчилгээг мэргэжлийн өндөр ур чадвар, олон

---

улсын чанар стандартын түвшинд хүргэх таатай орчин бүрдүүлэх, Улаанбаатар хотын түүх, бүтээн байгуулалттай холбоотой бүхий л соёлын өвийг цуглуулах, бүртгэх, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, сурталчлах, дэлгэн үзүүлэх төв байна.

#### ҮНЭТ ЗҮЙЛ:

Улаанбаатар хотын музей нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлах бөгөөд энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг эрхэмлэнэ.

- ❖ Мэргэшсэн байх – Ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд чадмаг, сурамгай гүйцэтгэх
- ❖ Хууль дээдлэх – Хуулийг дээдлэн хэлбэрэлтгүй сахин биелүүлэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах
- ❖ Шуурхай байх – Ажил үүргээ гүйцэтгэхдээ чирэгдэл учруулахгүй богино хугацаанд шийдвэрлэх
- ❖ Хараат бус байх – Нөлөөнд автахгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
- ❖ Ил тод байх – Хуулиар нууцын зэрэглэлд хамаарахаас бусад мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх
- ❖ Хариуцлагатай байх – Ажил үүргээ үнэнч шударгаар сайн, найдвартай гүйцэтгэдэг, үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг байх

Энэхүү эрхэм зорилгыг хангаж ажиллахын тулд дараах үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ;

#### ❖ *Эрхэмлэх зарчим1:*

Нийгмийн хямрал, элдэв нөхцөл шалтгааны улмаас үндэсний соёл устах, өв уламжлал алдрах, оюун санааны амьдрал ядууран доройтохоос бүх талаар сэрэмжлэх

#### ❖ *Эрхэмлэх зарчим 2:*

Түүх соёлын дурсгалт зүйлс сан хөмрөгийг үндэсний эрхэм баялаг гэж үзэж улс, нийслэлийн хамгаалалтад байлгах

#### ❖ *Эрхэмлэх зарчим3:*

Соёлын салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгон үр ашигтай гадаад харилцааг өргөжүүлэх

#### ❖ *Эрхэмлэх зарчим 4:*

Музейн үйл ажиллагааг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох

#### ❖ *Эрхэмлэх зарчим 5:*

Нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулахуйц, өрсөлдөх чадвар бүхий соёлын олон төрөл хэлбэрийг хөхүүлэн дэмжих, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хэрэглээнд нэвтрүүлэх

#### ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар хотын музей нь 2023-2024 онд баримтлах стратеги төлөвлөгөө боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дотоод болон гадаад орчны хүчин зүйлс ихээхэн үр нөлөөтэй тул дараах


орчны шинжилгээний дүгнэлт, үр дүнд тулгуурлан стратегийн зорилго, зорилт, үйл ажиллагаагаа тодорхойллоо.

**Дотоод орчны шинжилгээ:**

• **Төлөвлөлт**

2021 онд 34 арга хэмжээний 30 арга хэмжээ буюу 88,2 хувь нь бүрэн хэрэгжиж, 4 арга хэмжээ буюу 11,8 хувь нь хэрэгжих шатандаа 89 хүртэл хувьтай хэрэгжүүлж байсан. 2022 онд 51 арга хэмжээний 49 арга хэмжээ буюу 96 хувь нь бүрэн хэрэгжиж, 2 арга хэмжээ буюу 4 хувь нь л хэрэгжих шатандаа 89 хүртэл хувьтай хэрэгжүүлж байсан байна.

Зураг 2. Улаанбаатар хотын музейн 2021, 2022 оны төлөвлөгөөний биелэлт (хувиар)



2022 оноос эхлэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нийслэлийн харьяа байгууллагын удирдлагуудтай хариуцлагын гэрээ байгуулж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батладаг болсон.

• **Нөхцөл байдал**

Улаанбаатар хотын музейн хамгийн том тулгамдсан асуудлын нэг нь музейн барилга байгууламж болон албан хаагчдын ажиллах орчин юм. Музейн барилгад их засварын ажил хийгдэж байгаагүйн улмаас цахилгааны монтаж, хана, тааз, шал зэргийг шинэчлэх, сүүлийн 10 жил музейн ажилтнуудын компьютер, техник хэрэгсэл огт шинэчлэгдээгүйгээс ажилтнууд ажлаа хэвийн явуулахад хүндрэлтэй нөхцөл байдлууд үүсээд байсан. НЗДТГ-с музейн тулгамдсан асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх ажлын хүрээнд “Улаанбаатар хотын музейн барилгын



засвар, техник хэрэгсэл нийлүүлэх тухай” 202202289 дугаартай тендер 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдөр зарлагдаж “Онъ тэнгэрийн бичиг” ХХК гэсэн ганц байгууллага оролцож сонгогдсон. Засварын ажлыг 2022 оны 6-7 дугаар сарын хооронд хийгдэж, НХОГ-ын хариуцсан техникийн инженер хянан шалгаж хүлээн авсан ба тавилга эд хогшил, техник тоног төхөөрөмж нийлүүлэлт нь БНХАУ-н хил гааль хаалттай байгаагаас шалтгаалан хойшлогдсоор Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас тус компаний хүсэлтийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл гэрээг сунгасан. Манай байгууллага нь сүүлийн 20 жил тавилга эд хогшил, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдээгүй бөгөөд ашиглалтын хугацаа дууссан зарим эд хөрөнгөө актласан. Гэвч өнөөдрийг хүртэл тавилга эд хогшил, тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй, хүлээгдсээр байна.

• **Санхүүжилт**

Улаанбаатар хотын музей нь 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 542,800.000 төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрээ орон нутгийн төсвөөс 539,800.000 төгрөг, өөрийн орлогоор 3,000.000 төгрөгөөр тус тус тооцоолон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бол 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 568,731.200 төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3,060.000 төгрөг, нийт зарлагыг 571,791.200 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид тус тус хүргүүлсэн байна.

Мөн 2020 оноос музей нь Нийслэлийн багцад багтсанаас хойш Эрдэм шинжилгээний зардал, Үзмэр худалдан авах зардал, Түүх, соёлын дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтын зардал батлагдан төсөвлөгдөж музейн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд ахиц гараад байдаг. Музейн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, аж ахуйн зайлшгүй нөхцөл байдлыг сайжруулахад шаардагдах зардлууд төсөвт батлагдаж ирдэггүйгээс шалтгаалж дараах ажлуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг.

- Явуулын болон түр үзэсгэлэн зохион байгуулахад шаардагдах зардал
- Цаг үеийн холбогдолтой зохион байгуулах арга хэмжээний зардал
- Барилга байгууламжийн урсгал засварын ажлын зардал
- Галын болон гамшгийн аюул ослоос урьдчилан сэргийлэхэд шаардагдах зардал

Хүснэгт 5. 2022 оны Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Үндсэн үйл ажиллагаа (Хичээл, үйлдвэрлэлийн зардал 4%-ийг эзэлнэ.)	330,534.70	325,977.88	4,556.80	98.6%
Эрдэм шинжилгээний зардал	8,613.70	7,336.95	1,276.70	85.2%
Бусад урсгал зардал	8,972.60	8,672.70	300.00	96.7%

Үзмэр худалдаж авах зардал	12,000.00	3,250.00	8,750.00	27.1%
Түүх, соёлын дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалт	5,100.00	4,674.63	425.30	91.7%

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээрх гүйцэтгэлийн зөрүүгээр зардлыг хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байдаг.


### **Хүний нөөц**

Улаанбаатар хотын музей нь 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын А/504 захирамжаар 2019 оноос эхлэн 19 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

*Хүснэгт 6. Улаанбаатар хотын музейн бүтэц, орон тоо*


№	Албан тушаал	Батлагдсан орон тоо
1	Захирал	1
2	Менежер	1
3	Эрдэм шинжилгээний ажилтан	2
4	Сан хөмрөгч	1
5	Бүртгэл мэдээллийн санч	1
6	Тайлбарлагч	1
7	Боловсролын ажилтан	1
8	Арга зүйч	1
9	Дизайнер, зураач	1
10	Үзмэр хянагч	1
11	Архив, бичиг хэргийн ажилтан	1
12	Нягтлан бодогч	1
13	Нярав	1
14	Үйлчлэгч	1
15	Жижүүр	4
Нийт		19

Зураг 3. Албан хаагчдын албан тушаал (хүйс хувиар)




Нийт албан хаагчдын 10 хувь удирдах албан тушаалтан, 63 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан, 26 хувь нь туслах албан тушаалтан байна. Мөн 43 хувь нь эрэгтэй 57 хувь нь эмэгтэй байгаа нь хүйсийн харьцаа тэнцвэртэй байгаа нь харагдаж байна.

Зураг 4. Албан хаагчдын төрийн албанд ажилласан жил, хувиар



Албан хаагчдын 36,8 хувь 5 хүртэлх, 26,3 хувь нь 6-10 жил, 21,1 хувь нь 11-15 жил, 5,3 хувь 15-20 жил, 10,5 хувь нь 21-ээс дээш жил төрийн албанд ажилласан байна. Үүнээс харахад төрийн албанд 10-аас дээш жил ажилласан албан хаагчид 50-иас дээш хувийг эзэлж байна.

Зураг 5. Албан хаагчдын боловсролын түвшин (хувиар)



Музейн албан хаагчдын 15,7 хувь нь магистр, 63,2 хувь нь бакалавр, 21,1 хувь нь тусгай дунд боловсролтой байна.

Харъяа дээд байгууллага болон хамтын ажиллагаатай байгууллагуудаас мэргэжил арга зүйн чиглэлээр зохион байгуулагдсан нийт 25 удаагийн сургалт, семинар, хэлэлцүүлэг, лекцэд нийт 14 албан хаагчид хамрагдав.

Музейн албан хаагчдын дунд мэргэжлийн дагуу 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 19 албан хаагч хамрагдсан.

- **Үйлчилгээний чанар хүртээмж**

Барилгын бүтэц: Музейн барилга нь 1918 онд Буриад худалдаачин Цогт Гармаевич Бадамжав өөрийн хувийн эзэмшилд зориулан барьсан нэг давхар барилга. 1956 онд музейн барилга төвийн дулаан хангамжинд холбогдсоноор тус хэсэгт зоорийн давхар нэмж хийн дулааны узелийг байгуулжээ. Оффисийн өрөөг 1956 онд, сан хөмрөгийн өрөөг 2009 онд барьсан. 2012 онд цахилгааны дотор шугамыг бүрэн шинэчилж монтажласан.

Уг музейн барилга нь чулуун суурьтай, дүнзэн рамтай, савх модон шавардлагатай, шургааган ханатай, шавардлагатай модон дам нуруу хучилттай, модон шувуу нуруу, төмөр хучлагатай дээвэртэй, 7 өрөөтэй, 8.3x19.47м, 11.78x0.8м, хүзүүвч 2.6x3.36м хэмжээтэй 3 барилгаас бүрдсэн, нийт 215.4 м.кв талбайтай. Музейн газрын нийт хэмжээ нь 1385 м.кв, гадуураа төмөр хашаатай. Музей нь ачааны, суудлын, тусгай зориулалтын автомашингүй.

Өрөөний бүтэц:

- Сан хөмрөгийн өрөө -1
- Ажилтнууын өрөө - 2
- Үзүүллэгийн танхим - 2
- Үзэсгэлэнгийн танхим - 1


- Дулааны узелийн өрөө - 1
- 00-ийн өрөө - 1

Улаанбаатар хотын музей нь нийт 791 дэсийн 3440 ширхэг үзмэртэй. Үүнээс үзүүлэгийн танхимд нийт үзмэрийн 4 хувь орчмыг дэглэн үзүүлдэг. Сан хөмрөгийн өрөө нь 5x7 м буюу 35 м.кв талбайтай, зориулалтын бус, аж ахуйн аргаар баригдсан өрөөнд байрлаж байна. Өрөө нь 2 хэсгээс бүрдэх бөгөөд таазны өндөр 2.18 м. Өрөөнд файлын шүүгээ 2ш, үзмэрийн тавиур 6ш, чийгшүүлэгч төхөөрөмж 1ш, чийг дулаан хэмжигч төхөөрөмж 2ш байна.

2021 онд музей нь цар тахал ковидын нөхцөл байдлаас шалтгаалж 8 сар олон нийтэд музейн үзүүлэгийн танхимаар үйлчилгээ үзүүлээгүй бөгөөд энэ нь музейн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд нөлөөлж, тайлант хугацаанд 595,500 (таван зуун ерөн таван мянга таван зуу) төгрөгийг орлого төсөвт төвлөрүүлсэн.

2022 оны байдлаар музейд том хүн 599, оюутан 392, хүүхэд 1379, үнэ төлбөргүй 28, гадаад хүн 66 нийт 2464 үзэгч үйлчлүүлсэн.

Зураг 6. Үйлчилгээний суваг (тоогоор)



2021 онд цар тахал ковидын нөхцөл байдлаас шалтгаалан цахим орчинд хотын түүхийг сурталчлан таниулах ажиллагаа түлхүү хэрэгжүүлж, бүтээл үйлдвэрлэлийн оролцоог нэмэгдүүлсэн. 2022 онд үйлчлүүлэгч төвтэй үйл ажиллагааг идэвхүүлсэн байна.

### **Гадаад орчны шинжилгээ:**

Улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, технологи, хууль эрх зүй, хүрээлэн буй орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлох аргачлалаар ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг тооцоолсон.

## УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН ДОТООД БОЛОН ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ НЭГТГЭСЭН СВОТ ШИНЖИЛГЭЭ

### Хүснэгт 7. Свот шинжилгээ

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"><li>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан музейн төлөвлөгөөг боловсруулдаг.</li><li>- Музей нь өөрийн байранд үйл ажиллагаа явуулдаг.</li><li>- Нийслэлийн төсвөөс санхүүждэг.</li><li>- Албан тушаалын шаардлагад нийцсэн хүний нөөцөөр хангагдсан.</li><li>- Цахим орчноор дамжуулан хотынхоо түүхийг иргэдэд сурталчлан таниулдаг.</li><li>- Боловсролын хөтөлбөр болон бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх ажиллагаа явуулдаг.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Нэн шаардлагатай төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх санал оруулахад хэрэгждэггүй.</li><li>- Музейн стандартын шаардлага хангаагүй барилгад байрладаг. Байр талбай багтаамж муутай, ажиллах орчин, аюулгүй байдал, стандарт алдагдсан.</li><li>- Дараа оны төсвийн төсөөллийг музейн шаардлагад нийцүүлэн төсөвлөж өгснөөр батлагдаж ирдэггүй.</li><li>- Хүний нөөцийн хүртээмж муу, зарим ажилтнууд батлагдаагүй орон тооны ажлыг хавсран гүйцэтгэдэг.</li><li>- Үзүүллэг, үзэсгэлэнгийн танхим, сан хөмрөгийн өрөө стандартын шаардлага хангаагүй.</li></ul>
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"><li>- Техник технологи хурдтай хөгжиж, программ хангамж, цахим орчныг ашиглах боломж их.</li><li>- Засгийн газар, НЗДТГ-ын зүгээс соёлын салбарт анхаарал хандуулж эхэлж байна.</li><li>- Нийслэлд харилцаа холбооны сүлжээ харьцангуй сайн хөгжсөн.</li><li>- Соёлын салбарын иж бүрэн эрх зүйн орчин бүрдэж байна.</li><li>- Олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах боломж нээлттэй.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Нийслэл болон Соёлын Яамны дунд орхигдох эрсдэл гардаг.</li><li>- Зориулалтын байргүйн улмаас гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт тэнцдэггүй.</li><li>- Музейн барилгатай цахилгаан шугам сүлжээний дамжуулах дэд станц ойрхон байрладаг.</li></ul>

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Хотын өв соёл, түүхийн үнэ цэнийг бүс нутгийн хэмжээнд өсгөх, хүн амыг соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн соёлын үйлчилгээг өргөтгөх, олон улсын жишигт нийцсэн дэд бүтцийг бий болгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, соёлын өвийг цуглуулах, бүртгэх, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, сурталчлах, дэлгэн үзүүлэх төв байна.

Улаанбаатар хотын музей нь орчны шинжилгээний үр дүнд “тогтворжилтын стратеги”-ийг баримтлах нь оновчтой хэмээн тодорхойлж энэ хүрээнд сул талаа бууруулж боломжийг нэмэгдүүлэх, давуу талдаа тулгуурлан эрсдэлд өртөхгүй байхаар зорилго, үйл ажиллагаагаа төлөвлөж байна.

**Улаанбаатар хотын музейн 2023-2024 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах стратегийн зорилгыг дэвшүүлэв. Үүнд:**

*Хүснэгт 8. Улаанбаатар хотын музейн стратегийн зорилго*

<b>Стратегийн зорилго 1:</b>	<b>Нийслэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгагдсан музейд хамааралтай соёлын бодлогыг хэрэгжүүлэх</b>	<b>Боломжит бүхий л гарцыг ашиглан санал хүргүүлэх замаар төсөл хөтөлбөрийг шийдвэрлүүлэхийг зорино.</b>
<b>Стратегийн зорилго 2:</b>	Улаанбаатар хотын соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	Улаанбаатар хотын музейн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд боловсруулалт төлөвлөлтөөр соёлын өвийг цуглуулах, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, сурталчилан таниулна.
<b>Стратегийн зорилго 3:</b>	Музейн захиргаа, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болж хяналт шинжилгээ үр дүнд бодлого шийдвэрийн төлөвлөлт хийнэ.
<b>Стратегийн зорилго 4:</b>	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ил тод шилэн байх	Төсвийн зарцуулалт, хүний нөөц, өргөдөл гомдол, мэдээ мэдээлэл ил тод болсон байна.

---

## ДОЛОО. МУЗЕЙН ТАНИЛЦУУЛГА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Улаанбаатар хотын музей нь 1918-1919 онд баригдсан түүхэн дурсгалт барилгад 1956 онд “Улаанбаатар хотын түүхийн үзэсгэлэн” нэртэйгээр байгуулагдсан. 1960 онд Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей, 2011 онд “Улаанбаатар хотын музей” болж, нэрээ өөрчилсөн. Түүхэн хөгжлийн хувьд Улаанбаатар хотын музей нь 1961 оны 4-р сарын 20-ны өдрийн Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны даргын 29 дүгээр захирамжаар дүрэм нь батлагдан, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр тогтоож байжээ. Улаанбаатар хотын музей нь дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг.

- Сан хөмрөгийг баяжуулах
- Үзмэрийг бүртгэх, баримтжуулах
- Сан хөмрөг, үзмэрийг хадгалж хамгаалах
- Хотын түүх, соёлын хөдлөх, үл хөдлөх дурсгалыг судлах, хотын түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх
- Хотын түүх, соёлыг олон нийтэд сурталчлан таниулах

Музей нь анх байгуулагдсан цагаасаа одоог хүртэл хугацаанд 1919 онд хувийн сууцны зориулалтаар Оросын худалдаачин Цогтбадамжав гэдэг хүний бариулан эзэмшиж байсан түүх соёлын дурсгалт барилгад байрлаж байгаа тул музейн барилга нь он удаан жил элэгдэж, барилгын их засвар хийгдэж байгаагүйгээс музейн сан хөмрөгийг хадгалах болон бусад шаардлагыг хангахгүй, цаашид онцгой өөрчлөлт, их засвар хийхгүйгээр ашиглах бололцоогүй, зориулалтын бус барилгад үйл ажиллагаагаа явуулсаар байна. Одоогийн байдлаар сан хөмрөгийн 28 м.кв талбайд 3200 гаруй үзмэрийг маш эрсдэлтэй орчинд хадгалж байрны багтаамж багатайгаас шалтгаалж сан хөмрөгийн нийт үзмэрийн 4 хувийг үзүүлэхийн танхимд дэглэж, олон нийтийн хүртээл болгодог. Манай музей нь орчин үеийн стандарт, шаардлага хангасан музейн барилгагүй учраас музейгээс иргэд, олон нийтэд зориулсан боловсролын ажил, эвент арга хэмжээ, эрдэм шинжилгээ, судалгааны хурал, семинар, танин мэдэхүйн үзэсгэлэн, лекц, хичээл явуулахад хүндрэлтэй асуудлууд тулгарсаар байна.

Соёл бол аливаа улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа, Монголчуудын үндэсний бахархал, эв нэгдлийн эх сурвалж, хөгжил дэвшлийн хөшүүрэг, үндэсний оюуны дархлаа болохыг Монгол Улсын Төрөөс Соёлын талаар баримтлах бодлогод тусгасан байдаг. Шинэ тутам өөрчлөгдөж буй Монголын хөгжилд тогтвортой байр сууриа хадгалах хүчин зүйлүүдэд соёл орших бөгөөд, үндэсний төрхөө хадгалан, хотын болон нүүдэлчдийн соёл иргэншлийг зохистой түвшинд хослуулах ухааныг эрхэмлэн үндэсний соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, судалж сурталчлах замаар хойч үедээ өвлөн уламжлуулах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх эрхэм зорилго нь Төрийн захиргааны төв байгууллагаас эхлэн улс, орон нутгийн соёлын байгууллагуудын өмнө тавигдаж байгаа билээ.

Энэхүү хэрэгцээ, шаардлагаас үүдэж хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээг өргөтгөх, тэдний оюуны эрэлт хэрэгцээг хангах чиг үүрэг бүхий, музейн үйл ажиллагааг зах зээлийн эдийн засгийн харилцааны шаардлагад нийцүүлж, музейн менежмент, маркетинг, хүний нөөцийн удирдлагыг оновчтой хөгжүүлэх замаар олон нийтэд үзүүлэх үйлчилгээг мэргэжлийн өндөр ур чадвар, олон улсын чанар стандартын түвшинд хүргэх нь тулгамдсан асуудал болж байна.



---

Улаанбаатар хотын музей нь Монгол улсын нийслэл үүсч байгуулагдсан болон хөгжсөн түүх, нийгэм улс төр, соёл, шинжлэх ухааны ололт, амжилт, хөгжлийн түүхэн замнал, тогтлыг баримтжуулах, холбогдох түүх соёлын дурсгалт зүйлсийг цуглуулах, баяжлуулах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, сурталчлах замаар нийт иргэдэд таниулах, оюуны эрэлт хэрэгцээг нь хангах, танин мэдэхүй, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, түүх соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэх таатай орчин бүрдүүлэх, олон нийтэд ая тухтай нөхцөл, сэтгэл ханамжтай байдал бий болгох төв болох ёстой.